

**ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ ДАРГЫН АЖЛЫН БАЙРНЫ  
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА.**

**Гүйцэтгэх үүрэг:**

- Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн хүний нөөцийн асуудлыг тодорхойлох, хүний нөөцийн хөтөлбөрийг төлөвлөх, стратегийг боловсруулах, ажилчдын хүний нөөц бүрдүүлэх-хуримтлуулах-тэнцвэржүүлэх, тэднийг сонгон шалгаруулах, чиглүүлэх, сургах, зөвлөх, ажлын байрны мэдээлэл өгөгдлийг шинжлэх, ажилчдын гүйцэтгэлийг хянах, үнэлэх, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн ажлуудыг хариуцан хүний нөөцийн үйл ажиллагааг мэргэжил, аргазүйгээр удирдах,
- Байгууллагын хүний нөөцийн бодлого, дүрэм, журмыг судалж боловсруулах, мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;
- Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шинээр нэвтрүүлэх технологи, инновацийн ажлуудыг олон улсын түвшинд хүргэхэд стратегийн чиглэсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;

**Тавигдах шаардлага:**

- Анагаах ухааны их дээд сургуулийг хүний их эмч мэргэжлээр төгссөн;
- Магистр болон түүнээс дээш эрдмийн зэрэгтэй;
- Ахлах болон түүнээс дээш мэргэжлийн зэрэгтэй;
- Эмчлэх эрхийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх;
- Мэргэжлээрээ 10-аас дээш жил ажилласан байх;
- Удирдах албан тушаал эрхэлж байсан байх;
- Эрүүл мэндийн удирдлага болон удирдахуйн ухааны чиглэлээр мэргэжил дээшлүүлсэн байх;
- Хүний нөөцийн менежментийн чиглэлээр мэргэшсэн байх
- Гадаад хэлний дунд, түүнээс дээш түвшний мэдлэгтэй байх;
- Эерэг хандлагатай, багаар ажиллах, манлайлах ур чадвартай байх;

**Бүрдүүлэх материал:**

- Төрийн албан хаагчийн 1-р маягт /3\*4 цээж зураг-2%/
- Боловсролын түвшинг тодорхойлсон бүх баримт бичгүүд /нотариатаар гэрчлүүлсэн байх/
- Эмчлэх эрхийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар /Нотариатаар гэрчлүүлсэн байх/
- Иргэний үнэмлэхний хуулбар
- Хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар
- Ажилд орохыг хүссэн өргөдөл

Дээрх шаардлагыг бүрэн хангасан материалыг УНТЭ-ийн Захиргааны 5 давхарт 504 тоот өрөө, Захиргаа, хүний нөөцийн албанд 2020.10.26-ны өдрийг дуустал хугацаанд хүлээн авна. Утас:77111017

**Сонгон шалгаруулалтыг дараах байдлаар зохион явуулна. Үүнд:**

1. Баримт бичгийн шалгаруулалт
2. Онолын шалгалт
3. Ярилцлагын шалгалт